



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

**ЗАВХАН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАРТ**

2024.02.06

№

30

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5 төсөл хөтөлбөрийн хүрээнд 126 иргэнд 769.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 394 иргэний 595.2 сая төгрөг эргэн төлөгдсөнөөр сангийн авлагын үлдэгдэл 2,954.4 сая төгрөг болжээ.

Аудитын гол асуудал

2015-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдсан 397 иргэний 1,201.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг гэрээт хугацаандаа эргэн төлөгдөөгүй байна. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 392 иргэний 1,188.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулахаар шүүхэд материалыг хүргүүлсэн, 5 иргэний 12,5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар иргэдэд мэдэгдэх хуудас хүргүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1431 иргэнийг байнгын болон түр ажлын байраар ханган, 604 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Audit(D)Зөвлөмж/2024

013000017

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА